



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/623

Хэрлэн сум

Аймгийн “Оны онцлох хүүхэд”
шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн “Оны онцлох хүүхэд” шалгаруулах журмыг нэгдүгээр хавсралтаар, “Оны онцлох хүүхэд”-д нэр дэвшиж байгаа хүүхдүүдийн анкетыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Оны онцлох хүүхэд” шалгаруулах журмын хэрэгжилтийг орон нутагтаа хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/644 захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дүгээр сарын 03 -ний өдрийн
А/623 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН "ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД" ШАЛГАРУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

Үндэслэл

"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 2.3.2 дахь заалтад заасан "Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана" гэж заасан байдаг. Түүнчлэн Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад "Хүүхэд оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах" эрхтэй гэж заасны дагуу Хэнтий аймгийн "Оны онцлох хүүхэд" шалгаруулах

Нэг. Зорилго

1.1. Хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах хүрээнд үндэсний болон олон улс, тив, дэлхийн түвшинд мэдлэг, авьяас, хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлаг, оюун ухаан бусад төрлөөр амжилт гарган манлайлсан Хэнтий аймгийн "Оны онцлох хүүхэд"-ийг шалгаруулж, олон нийтэд алдаршуулах, өсвөр үеийнхэнд үлгэр дуурайлал болгох сайн үйлийг түгээн дэлгэрүүлэхэд оршино

Хоёр. Аймгийн "Оны онцлох хүүхэд"-ийг шалгаруулах ерөнхий зүйл

2.1. Аймгийн "Оны онцлох хүүхэд"-ийг дараах 9 төрлөөр шалгаруулах ба тухайн жилд гаргасан хүүхдийн амжилтыг гол үзүүлэлт болгоно. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үндэсний болон олон улс, тив, дэлхийн оюун ухаан, техник сэтгэлгээ, соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадам, олимпиадад оролцож тухайн жилд онцгой амжилт гаргасан бол төрөл тус бүр дээр хүүхдийн тоонд хязгаарлагдахгүй ирүүлж болно. Үүнд:

1. Техник сэтгэлгээ, шинэ санаачилга, бүтээлч байдал төрөл

Хүүхэд өөрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх шинэ бүтээл, оновчтой санал гарган хэрэгжүүлж, хийсэн бүтээл, туурвилаараа олон улс, тив, дэлхийн болон үндэсний хэмжээнд уралдаан тэмцээнд оролцож шалгарсан, олон нийтийн хүртээл болгосон байх

2. Сурлагын амжилт төрөл

Сурлагын үзүүлэлтээр жил дараалан тогтмол амжилттай суралцаж, боловсролын байгууллагаас зохион байгуулдаг албан ёсны аймаг, улс, бүсийн чанартай олимпиад тэргүүлсэн, олон улс, тив дэлхийн олимпиад, уралдаан тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн оролцож өндөр амжилт үзүүлсэн байх

3. Урлаг, уран бүтээл төрөл

Урлаг, уран сайхны авьяастай, өөрийн хичээллэдэг урлагийн салбарт амжилт гаргаж, уран бүтээл туурвисан байх, олон улс, тив, дэлхийн, үндэсний, бүсийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцож тухайн жилд онцгой амжилт гаргасан байх

4. Биеийн тамир, спорт төрөл

Спортын төрлөөр дагнан хичээллэж олон улс, тив, дэлхийн, үндэсний, бүсийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцож тухайн жилд онцгой амжилт гаргасан байх

5. Монгол ёс, түүх, соёлыг өвлөн уламжлагч төрөл

Монгол түүх, соёл, өв уламжлалыг өвлөн тээгч, үе тэнгийнхэндээ түгээн дэлгэрүүлж, олон нийтэд сурталчилсан, бие даан бүтээл туурвисан байх

6. Байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчин төрөл

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зорилготой хүүхдийн хөдөлгөөнийг санаачлан байгуулсан, сайн дураараа идэвхтэй оролцсон байх, байгаль экологийн сурталчилгаа хийж, хүүхэд өсвөр үеийнхэн, олон нийт, хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулсан байх, байгаль экологийн чиглэлээр улсдаа тэргүүлсэн, олон улс, тив дэлхий, бүсийн олимпиад, уралдаан тэмцээнд Монгол улс, Хэнтий аймгаа төлөөлөн оролцож өндөр амжилт үзүүлсэн байх

7. Хүмүүнлэг, энэрэнгүй сайн үйлс төрөл

Байгалийн гамшигт үзэгдлээс хүний амь насыг аварсан, эрсдэлт нөхцөлд байгаа үе тэнгийнхэндээ тусалсан, олон нийтийн сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй, амжилттай зохион байгуулсан байх

8. Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллага төрөл

Хүүхдийн оролцооны өөрийн удирдлагын байгууллага, хамт олноос хүлээлгэсэн сонгуульт үүргийг хариуцлагатай биелүүлж, зөв үлгэр дуурайлал, манлайлал үзүүлсэн, шинэ санал санаачилга бүхий үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгуулсан, хүүхдийн асуудлаар олон улсын болон үндэсний хурал, чуулганд сонгогдсон оролцсон, хүүхдийн төлөөллийн үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн байх

9. Багийн амжилт төрөл

Тухайн жилд анги, баг, хамт олон, клуб, оролцооны байгууллага болон тухайн бүрэлдэхүүний сурагч тус бүр сурлага, оюун ухаан, техник сэтгэлгээ, урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээнд олон улс, тив дэлхийн болон үндэсний, бүсийн хэмжээний тэмцээн, уралдаанд оролцож онцгой амжилт гаргасан байх

10. Оюун ухааны спортын төрөл

Шатар, даам болон бусад оюун ухааны спортын төрлөөр олон улс, тив дэлхийн болон үндэсний хэмжээний тэмцээн, уралдаанд оролцож онцгой амжилт гаргасан байх.

2.2. Аймгийн “Оны онцлох хүүхэд”-д тавигдах шаардлага:

- Нэр дэвшигч нь 6-18 хүртэлх насны хүүхэд байна.
- Нэр дэвшигч нь хамт олондоо нэр хүндтэй, үлгэр дуурайлал болсон, тэргүүний, манлайлагч хүүхэд байна.
- Нэр дэвшигч нь тухайн жилд нэр дэвшиж буй төрөлдөө тив, дэлхийн, олон улс, үндэсний хэмжээний тэмцээн, уралдаан, олимпиадад оролцож онцгой амжилт гаргасан байна.

Гурав. Үйл ажиллагааны зохион байгуулалт, шалгаруулалт

Аймгийн “Оны онцлох хүүхэд” шалгаруулах үйл ажиллагааг 2 үе шаттай зохион байгуулна.

3.1 Нэгдүгээр үе шат

3.1.1 Сум, тосгоны ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллеж тус бүр “Оны онцлох хүүхэд”-д нэр дэвшигчдийн материалыг төрөл тус бүр дээр 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хүлээн авч, шалгаруулалтыг хийж төрөл тус бүрд 1 хүүхдийн материалыг 11 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт ирүүлнэ.

3.1.2 Төрөл тус бүр дээр шалгарсан 1 хүүхдийн материалыг ирүүлэхдээ хавсралтад заасан маягтын дагуу товъёог үйлдэж, албан бичгээр баталгаажуулж ирүүлнэ. Үүнд:

- Сум, тосгоны ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллеж тус бүрээс төрөл тус бүрд шалгарсан хүүхдүүдийн мэдээлэл бүхий албажуулсан жагсаалт
- Нэр дэвшигч хүүхдийн анкетийг бүрэн бөглөсөн байх, аймгийн “Оны онцлох хүүхэд”-д нэр дэвшүүлэх тодорхойлолт (Эрх бүхий байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх, амжилтын жагсаалтыг тодорхойлолтод дарааллаар дурдсан байна.
- Нэр дэвшигч хүүхдийн гаргасан амжилтыг гэрчлэх баримт бичиг (үнэмлэх, гэрчилгээ)-ийн хуулбар, биет бүтээлийн фото, видео аудио, зургийг хавсаргаж ирүүлнэ. (Медаль, цом болон бусад биет материалыг ирүүлэх шаардлагагүй).
- Хүүхдийн фото зураг (Нэр дэвшигчийн гаргасан амжилтыг сурталчлан олон нийтэд мэдээлэн цахимд байршуулах учир зургийн чанарыг хангасан байхад анхаарах)

3.1.3 Аймгийн "Оны онцлох хүүхэд"-д нэр дэвшигчдийг шалгаруулсан тухай тайлан, хурлын тэмдэглэлийг ирүүлнэ. (Төрөл тус бүрд хэдэн хүүхдийн материал ирсэн, сум тосгоны сургуульдаа шалгарсан хүүхэд бусад хүүхдээс амжилтаараа давуу гэдгийг баталсан тайлбарын хамт ирүүлнэ)

3.1.4 Нэр дэвшигчийн материал хүлээн авахгүй байх тохиолдол (Хугацаа хоцорсон болон материалын бүрдэл дутуу, өмнөх жилүүдийн "Оны онцлох хүүхэд" шалгаруулах арга хэмжээнд оролцсон, гаргасан амжилтаа ахиулаагүй нэр дэвшигчийн материалыг хүлээн авахгүй)

3.2 Хоёрдугаар үе шат

3.2.1 Аймгийн "Оны онцлох хүүхэд"-д сум, тосгоны ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежоос нэр дэвшсэн хүүхдүүдээс төрөл тус бүрд 1 хүүхдийг шалгаруулахдаа тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны дотор багтаан улсын "Оны онцлох хүүхэд" шалгаруулах шалгаруулалтын дүн гарснаас хойш аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба буюу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас санал дүгнэлтийг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шалгаруулна. (Шалгуур үзүүлэлт хангаагүй бол шалгаруулахгүй байж болно)

3.2.2 Аймгийн "Оны онцлох хүүхэд"-ээр шалгарсан хүүхдийн авьяас, чадварыг аймгийн хэмжээнд олон нийтэд түгээх, алдаршуулах, хүндэтгэл үзүүлэх ажлыг аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба буюу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хариуцан салбар дундын хамтын ажиллагааг хангаж зохион байгуулна.

3.2.3 "Оны онцлох хүүхэд" шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлтийг 11 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө бичгээр ирүүлж болно.

Дөрөв. Шагнал урамшуулал

4.1. Аймгийн "Оны онцлох хүүхэд"-ийн шагналыг аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн гардуулна.

4.2. Аймгийн "Оны онцлох хүүхэд"-ээр шалгарсан хүүхэд бүрийг батламж, 100,000 төгрөг, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулна.

4.3. Аймгийн "Оны онцлох хүүхэд"-ээр шалгарсан хүүхэд бүрийн амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, хүүхэд, өсвөр үеийнхэнд үлгэр дуурайлал болгон алдаршуулна.

Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 03 -ний өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

12
A/623

ОНЫ ХЭНТИЙ АЙМГИЙН "ОНЫ ОНЦЛОХ ХҮҮХЭД"-ИЙН
ТӨРӨЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

1. Ургийн овог:
2. Эцэг эхийн нэр:
3. Өөрийн нэр:
4. Регистрийн дугаар:
5. Нас, хүйс:
6. Яс үндэс:
7. Үндсэн захиргаа:
8. Сургууль:
9. Анги, бүлэг:
10. Хийсэн үйл ажиллагаа:

Д/д	Үйл ажиллагааны нэр	Хамрах хүрээ	Хугацаа	Хамтран зохион байгуулагчид
1.				
2.				
.....				

11. Шагнагдсан байдал:

Д/д	Шагналын нэр	Байгууллагын нэр	Шагнагдсан он
1.			
2.			
.....			

12. Шагнуулах үндэслэл: (Товч, тодорхой үйл ажиллагааг багцалж, базаж бичнэ)

13. Нэр дэвшигчийн мэйл хаяг:
14. Фэйсбүүк хаяг:
15. Холбоо барих утасны дугаар: